



КРЕДИТ
ББСБ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 4 сарын 24-ний өдөр

№ 2025/25

Улаанбаатар хот

Сонирхолын зөрчилтэй
хэлцэл батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.2, 76.1.17 дахь заалт, 92 дугаар зүйлийн 92.1, 92.4 дэх заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн санал хураалтын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Айдакс ХХК (РД:6803016)-д 101,011 (нэг зуун нэг мянга арван нэг) ам.долларын Шугамын зээлийн эрхийг дараах нөхцөлөөр нээхийг зөвшөөрсүгэй.

Зээлийн хүү	12% /жилийн /
Комитмент хүү	5% /жилийн/
Зээлийн хугацаа	24 сар
Зээл олголтын шимтгэл	1%
Зээлийн зориулалт	Эргэлтийн хөрөнгө санхүүжүүлэх

2. Зээлийн барьцаанд 100,000 USDT буюу Ам долларын теттерын нөөц барьцаалж, барьцааны гэрээ байгуулахыг зөвшөөрсүгэй.
3. Тогтоолын хэрэгжилтийг хангуулан зээлийн гэрээ болон барьцааны гэрээ байгуулах, компанийг төлөөлж холбогдох бичиг баримтад гарын үсэг зурах эрхийг олгож, зээлдэгчид зээл олголтыг хийхийг Гүйцэтгэх захирал (Г.Сүхбаатар)-т даалгасугай.
4. Энэхүү санал хураалтад сонирхлын зөрчилгүй этгээдүүд оролцож шийдвэр гаргасан болохыг дурдсугай.
5. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын Хороо (В.Ганзориг)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАНЗОРИГ